

"Гарын авлага" -ын заавал мөрдөх хэсэг: Ковид-19-ийн улмаас 2020/2021 оны хичээлийн жилд сургууль болон сургуулийн байгууллагуудын үйл ажиллагаа

Энэ бол Боловсрол, Залуучууд, Спортын Яамнаас 2020 оны 9-р сарын 1-ний өдрөөс эхлэн сургуулийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой гэж үзсэн хүчинтэй хууль эрх зүйн зохицуулалттай холбогдох заавал дагаж мөрдөх журмын талаарх мэдээлэл юм.

Маск – Сургууль болон сургуулийн байгууллагуудад **маск зүүх үүрэггүй**. Гэсэн хэдий ч олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад маск зүүх үүрэгтэй байж болно. Маск зүүх үүргийг хэрэгжүүлэх нь гэрлэн дохио гэж нэрлэгддэг нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлийн бэлэн байдлын шатлалаар зохицуулдана. Дүүрэг нь бэлэн байдлын II-р түвшинд (үлбар шар өнгө) орсон тохиолдолд тухайн мужийн эрүүл ахуйн станц нь сургууль болон сургуулийн байгууламжийн нийтийн талбайд маск зүүх үүргийг хэрэгжүүлнэ.

Ковид-19-ийн өвчлөлтэй холбоотой онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд сургууль Мужийн эрүүл ахуйн станцын зааврыг биелүүлэх ба Эрүүл мэндийн яамнаас нийтээр юмуу Мужийн эрүүл ахуйн станцаас тухайн бүс нутагт зарласан мөрдөж байгаа бүх онцгой арга хэмжээг дагаж мөрдөх үүрэгтэй.

Ковид-19-ын халдварын сэжиг бүхий тохиолдолд сургууль дараахь алхмуудыг хийнэ:

Сургуулиуд халдварт өвчин, мөн ковид-19 үүсэх ба тархахаас урьдчилан сэргийлэх үүрэгтэй. Энэхүү үүргийг нийгмийн эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн дагуу “цочмог өвчний шинж тэмдэг илэрч буй хүүхэд, өсвөр насны хүүхдийг бусад хүүхдүүд, өсвөр насны хүүхдүүдээс тусгаарлаж” тэдэнд насанд хүрсэн этгээдийн хяналт байлгаж (Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн (§73-ийн 3-р догол мөр) ханган биелүүлнэ.

Тус сургууль нь хүүхдүүд/сурагчид/оюутнуудад халдварт өвчний шинж тэмдэг (өндөрссөн халуунтай байх, халуурах, ханиалгах, ханиадтай байх, амьсгал давчдах, хоолой өвдөх, толгой өвдөх, булчин, үе мөч өвдөх, гүйлгэх, амт, үнэр мэдрэхгүй байх г. м.) илэрч буй эсэхийг нэгбүрчлэн илрүүлэх үүрэг хүлээхгүй, иймээс эдгээр шинж тэмдгүүдэд илүү их анхаарал хандуулах нь зүйтэй бөгөөд тэдгээрийг илрүүлэх (олж мэдэх)-эд дараахь аргыг сонгож байна:

- хүүхэд/сурагч /оюутан сургууль дээр ирэхэд шинж тэмдгүүд аль хэдийн мэдэгдэж байх - хүүхэд/сурагч /оюутныг сургуулийн байранд оруулахгүй; хүүхэд эсвэл насанд хүрээгүй сурагч байгаа тохиолдолд хууль ёсны төлөөлөгч нь байгаа бол,
- хүүхэд/сурагч сургууль дээр ирэхэд шинж тэмдгүүд илт мэдэгдэх байх ба хүүхдийн болон насанд хүрээгүй сурагчийн хууль ёсны төлөөлөгч нь байхгүй байх – энэ бодит байдлыг хууль ёсны төлөөлөгчдөд нь цаг алдалгүй мэдэгдэж улмаар сургуулиас нэн даруй авч явах/тосож авах/гарч явах шаардлагатай байгааг түүнд мэдэгдэнэ; хэрэв энэ боломжгүй бол дараахь зааврын дагуу үргэлжлүүлнэ үү,
- шинж тэмдэг хүүхэд, сурагч/ оюутанг сургууль дээрээ байгаа илэрвэл; нэн даруй маск олгож өгөөд урьдчилан бэлтгэсэн тусдаа өрөөнд байрлуулах юмуу өөр аргаар сургуульд байгаа бусад хүмүүсээс тусгаарлаж, түүнчлэн хүүхэд/насанд хүрээгүй сурагчийн хууль ёсны төлөөлөгчид мэдэгдэж, хүүхэд/сурагчийг сургуулиас нэн даруй авч явах тухай мэдээлэх; насанд хүрсэн сурагч/оюутан аль болох хурдан сургуулийн байрыг орхиж гарна.

Эдгээр бүх тохиолдолд сургууль хууль ёсны төлөөлөгчд, насанд хүрсэн сурагч юмуу оюутныг утсаар дараачийн хийх алхмын тухай шийдвэр гаргах өрхийнхөө эмчтэй холбоо барих тухай мэдээлнэ.

Халдварт өвчний шинж тэмдэг илэрдэг архаг өвчин - Архаг өвчин, түүний дотор харшлын өвчин (ханиад, ханиалгах) өвчний илрэл болох халдварт өвчний байнгын шинж тэмдэг илэрсэн хүүхэд/сурагч/оюутныг зөвхөн халдварт өвчнөөр өвдөөгүй гэдгээ нотолсон тохиолдолд л сургуульд орохыг зөвшөөрнө. Энэ нь халдварт өвчин биш болохыг хүүхэд, өсвөр насныхны өрхийн эмч нотолж тодорхойлно. Эмчийн тохорхойлолтыг өгсний дараа хүүхэд, өсвөр насныхныг сургуулийн байранд орохыг зөвшөөрнө. Тодорхойлолтыг нэг л удаа авчирч өгнө.

Алсын зайн сургалт - 9-р сарын 1-ээс эхлэн хүүхэд/сурагч/оюутны боловсрол өдрөөр сурах горимд эргэж орж байна, алсын зайны сургалтын горим нь хямрал юмуу онцгой арга хэмжээ эсвэл тогтоосон хорио цээрийн дэглэмээс болж дор хаяж нэг бүлэг/анги/тэнхим/курсын **ихэнх** хүүхдүүд/сурагчид/оюутнууд **биеэрээ оролцох** боломжгүй болсон зөвхөн Боловсролын тухай хуульд бэлтгэсэн нэмэлт, өөрчлөлтөд заасан тохиолдолд л байна. Боловсролын алсын зайны сургалтад шилжих талаарх шийдвэрийг дээр дурдсанаас өөр тохиолдолд сургуулийн захирал эсвэл хууль ёсны төлөөлөгч гаргаж боломжгүй.

Ийм байдлаар тухайн нөхцөл байдалд боловсрол олгох үүрэг нь бага сургууль, дунд сургууль, консерваторууд, мэргэжлийн дээд сургууль, үрлагийн бага сургууль ба хэлний улсын шалгалт авах эрхтэй хэлний сургуулиудад хамаарна. Цэцэрлэг сургуулийн өмнөх боловсрол заавал авах ёстой хүүхдүүдэд алсын зайны боловсрол олгох үүрэгтэй байна, тэгэхдээ ингэж зохион байгуулагдсан ангийн юмуу цэцэрлэгийн хэмжээний эсвэл тусдаа хичээллэх байрны хэмжээний ихэнх хүүхдүүдийн оролцож чадахгүй тохиолдолд. Эдгээр хамааралтай хүүхдүүд/сурагчид/оюутнуудын өдрөөр хичээллэх горим нь зайны сургалтад (алсын зайны сургалтын нөхцөлийг харгалзан үзсэнээр) шилжинэ. Хориг хамаарахгүй бусад хүүхдүүд/сурагчид/оюутнууд өдрийн ангид үргэлжлүүлэн суралцана. Тэд нэг бүлэгт хамрагдаж нэг дор байх нь дээр.

Сурагчид, оюутнууд алсын зайны боловсрол эзэмших үүрэгтэй. Цэцэрлэгийн хүүхдүүдийн хувьд энэ үүрэг сургуулийн өмнөх боловсрол заавал эзэмших ёстой хүүхдүүдэд хамаарна.

Сургууль нь алсын зайны боловсролыг үнэлгээг хүүхдүүд/сурагчид/оюутнуудын үнэлгээний нөхцөлтэй нь бас уялдуулах үүрэгтэй.

Бусад тохиолдолд сургууль алсын зайны боловсрол олгох үүрэггүй. Тэгээд сургууль хүүхдүүд/сурагчид/оюутнууд сургуульд байгаагүй ердийн байдлын тохиолдолтой адилаар авч үзнэ. Хэрэв сургуулийн зохион байгуулалтын хувьд боломжтой бол тэдний сайн дурын үндсэн дээр, тэдний нэгбүрчилсэн нөхцөл байдлыг харгалзан үзэж холбогдох хамааралтай хүүхдүүд/сурагч/оюутнуудад ядаж хэсэгчлэн алсын зайны боловсрол эзэмшүүлэх нь зүйтэйг зөвлөж байна.

Эх үүсвэр *БЗСЯмны цахим хуудас*, 2020.8.24

<https://www.msmt.cz/nejcastejsi-dotazy-ke-skolstvi-a-koronaviru-1>